



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/65

Биндэр сум

Ерөнхий боловсролын сургуулийн
хүүхэд хамгааллын баг шинэчлэн
томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хувь хүний нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4, 6 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7, 8 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Биндэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:	Ерөнхий боловсролын сургуулийн захирал
Гишүүд:	Ахлах бүлгийн сургалтын менежер
	Дунд бүлгийн сургалтын менежер
	Бага бүлгийн сургалтын менежер
	Сургуулийн Сэтгэл зүйч
	Сургуулийн эмч
	Дотуур байрны багш

Нарийн бичгийн дарга: Нийгмийн ажилтан

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Биндэр сумын Засаг даргын 2023 оны А/114 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Биндэр сумын Хүүхэд хамгааллын багтай хамтарч ажиллахыг ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын багт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

